



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/330

Мөрөн сум

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 36 дугаар зүйлийн 36.6, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаал, 2021 оны 102 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөв, санхүүгийн талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой “Манлайлагч санхүүгийн алба” аяны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, шалгаруулах болзлыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Аяны удирдамж, дүгнэх үзүүлэлтийн дагуу үнэлгээний аргачлалыг боловсруулан, дүгнэж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), Орон нутгийн өмчийн газрын дарга (Х.Цэнд-Аюуш), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог), Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Догсмоо) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 06
дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

“МАНЛАЙЛАГЧ САНХҮҮГИЙН АЛБА” АЯНЫ УДИРДАМЖ

Зорилго: “Төсвийн тухай хууль”, “Төсвийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилт болон дотоод хяналтын түвшинг сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, сумын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад аяны зорилго оршино.

Зорилт: 1. Салбарын байгууллагуудын хариуцлага хамтын ажиллагааг эрчимжүүлэх
2. Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх
3. Төрийн албан хаагчын ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх
4. Төрийн сангийн дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах
5. Төсвийн ил тод байдлыг хангах
6. Төрийн сангийн үйл ажиллагаа, орон нутгийн өмчийн бүртгэл хяналтын үр дүнг дээшлүүлэх
7. Төсвийн байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Хамрах хугацаа: Жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр

Хамрах хүрээ: 23 сум, 1 тосгоны санхүүгийн болон дотоод хяналтын ажилтнууд

Үнэлэх зарчим: Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын албаны дүгнэх үзүүлэлтүүд болон үнэлгээний аргачлал тус тусдаа байна. Нийт үнэлгээний 50 хувийг СТСХ-ийн үнэлгээ, 15 хувийг ОНӨГ-ийн үнэлгээ, 15 хувийг ХААГ-ийн үнэлгээ, 20 хувийг СХАА-ны үнэлгээ тус тус эзлэх бөгөөд үнэлгээг өссөн дүнгээр дүгнэж, байр эзлүүлнэ.

Аяны дүн: Хагас жилийн дүнг 7 сарын 15-ны дотор, жилийн дүнг дараа оны 1 сарын 30-ны дотор нэгтгэн дүгнэнэ.

Шагнал: Дөрвөн байгууллагын нийлбэр дүнгээр шалгарсан санхүүгийн албыг Манлайлагч санхүүгийн албаар өргөмжлөн, мөнгөн шагнал, мөн эхний 5 байрыг дараах байдлаар шагнаж урамшуулна.

- 1 дүгээр байранд орсон санхүүгийн ажилтнуудыг үндсэн цалингийн 30 хувиар,
- 2 дугаар байранд орсон санхүүгийн ажилтнуудыг үндсэн цалингийн 25 хувиар,
- 3 дугаар байранд орсон санхүүгийн ажилтнуудыг үндсэн цалингийн 20 хувиар,
- 4 дүгээр байранд орсон санхүүгийн ажилтнуудыг үндсэн цалингийн 15 хувиар,
- 5 дугаар байранд орсон санхүүгийн ажилтнуудыг үндсэн цалингийн 10 хувиар тус тус нэг удаа шагнаж урамшуулна.

Хариуцлага: Нэгдсэн үнэлгээгээр 2 жил дараалан сүүлийн 3 байранд орсон тохиолдолд тухайн сумын санхүүгийн албан хаагчдад хариуцлага тооцох саналыг удирдлагад хүргүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2024 оны 06
дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

“МАНЛАЙЛАГЧ САНХҮҮГИЙН АЛБА” АЯНЫ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

№	Дүгнэх үзүүлэлт	Дүгнэх мэргэжилтэн	Дүгнэх хугацаа	Онооны систем
1. Сарын мэдээ				
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн өр, авлагын мэдээ	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүд, Төрийн сангийн ДХБҮАЗБ мэргэжилтэн	Сар бүр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ	Төсвийн зарлагын БҮАЗБ мэргэжилтэн		
3	Төсвийн орлогын гүйцэтгэлийн мэдээ	Төсвийн орлогын БҮАЗБ мэргэжилтэн		
4	Санхүүжилт олгосон байдал	Төсвийн ерөнхий нягтлан бодогч		
5	ОНХС-ийн удирдлага мэдээллийн системийн хэрэгжилт	Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн		
2. Санхүүгийн тайлан				
6	Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлсэн хугацаа	Төсвийн ерөнхий нягтлан бодогч	2, 3 дугаар улиралд	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
7	Тайлангийн алдаа, зөрчлийн дүн			
8	Өр, авлагын өсөлт, бууралт			
9	Тайлангийн иж бүрдэл			
3. Төсвийн төлөвлөлт, хуваарилалт				
10	Дараа оны төсвийн төслийн санал ирүүлэх, системд шивэх	Төсвийн зарлагын болон орлогын бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтнүүд	3 дугаар улиралд	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
11	Дараа оны төсвийг сумын ИТХ-р батлуулж тогтоол, сарын хуваарийг ирүүлэх		4 дүгээр улиралд	
12	Төсөвт тодотгол хийсэн байдал		Тухай бүр	
4. Төрийн сангийн төлбөр тооцоо, дотоод хяналт				

13	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтын үнэлгээ, зөвлөмжийн хэрэгжилт	Төрийн сангийн дотоод хяналтын бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн	Жилийн эцэст	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
14	Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт		Жилийн эцэст	
15	Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын хэрэгжилт		Улирлаар, жилээр	
16	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем		Хагас болон бүтэн жилээр	
17	Эрхийн бүртгэлийн сангийн систем		Хагас болон бүтэн жилээр	
18	Төрийн сангийн цахим шилжилтийн хэрэгжилт		Жилээр	
19	Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээлийн системд дагаж мөрдөх журмын хэрэгжилт		Жилээр	
20	Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал, зарлагын хөтөлбөр, зориулалтын ангиллыг мөрдөж байгаа эсэх		Хагас болон бүтэн жилээр	
21	Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмын хэрэгжилт	Төсвийн ерөнхий нягтлан бодогч, Төрийн сангийн дотоод хяналтын БҮАЗБ мэргэжилтэн	Жилээр	
5. Аж ахуйн нэгжийн тайлан				
22	Аж ахуйн нэгжүүдийн тайлангийн ирц	Нягтлан бодох бүртгэлийн БҮАЗБ мэргэжилтэн	1 дүгээр улиралд	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
23	Тайлангийн чанар			
6. Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал				

24	Санхүүгийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ажлын хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд хийсэн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүн			
25	Шинэ санаа, сайн туршлагаа түгээсэн, мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар өөрийгөө дайчлан ажилласан, мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн чиглэлээр сургалтанд хамрагдсан байдал	Хэлтсийн мэргэжилтнүүд	бүх	Жилийн эцэст
				5 хүртэлх оноогоор дүгнэнэ.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

№	Дүгнэх үзүүлэлт	Дүгнэх мэргэжилтэн	Дүгнэх хугацаа	Онооны систем
1	Санхүүгийн хяналт, шалгалт болон дотоод аудит	Дотоод аудитор	Жил бүрийн 6 дугаар сарын 20. 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тайланг ирүүлсэн байх.	5 хүртэл оноогоор дүгнэнэ
2	Эрсдлийн үнэлгээ	Дотоод аудитор		5 хүртэл оноогоор дүгнэнэ
3	Орон тооны бус дотоод аудитын нэгжийн үнэлгээ.	Дотоод аудитор		2.5 хүртэл оноогоор дүгнэнэ
4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Дотоод аудитор		2.5 хүртэл оноогоор дүгнэнэ
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал	Дотоод аудитор		5 хүртэл оноогоор дүгнэнэ

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

№	Дүгнэх үзүүлэлт	Дүгнэх мэргэжилтэн	Дүгнэх хугацаа	Онооны систем
1	Өмч эзэмшлийн гэрээг дүгнүүлж, дараа оны гэрээг байгуулсан байдал	Холбогдох мэргэжилтэн	Хагас болон бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор
2	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээ ирүүлсэн байдал	Холбогдох мэргэжилтэн	Хагас болон бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор

3	Хөрөнгө бүртгэх тухай шийдвэрийн хэрэгжилт /Орлогын баримт, ҮХ-1 маягт ирүүлсэн байдал/	Холбогдох мэргэжилтэн	Хагас болон бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор
4	Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн мэдээ ирүүлсэн байдал	Холбогдох мэргэжилтэн	Хагас болон бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

1. ХАА-ы төлөвлөлт /15 оноо/				
1.1	ХАА-ны төлөвлөгөөний төслийг цаг хугацаанд нь ирүүлсэн эсэх	Төлөвлөгөө нэгтгэсэн мэргэжилтэн	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
1.2	Хуулийн 48.4-т заасны дагуу батлагдсан төлөвлөгөөг www.tender.gov.mn оруулж, Сангийн яаманд хугацаанд нь ирүүлсэн эсэх	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
1.3	ХАА-ны төлөвлөгөөг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, олон нийтэд мэдээлсэн эсэх	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
2. ХАА-ы тайлагнал /10 оноо/				
2.1	ХАА-ны жилийн эцсийн тайлан цаг хугацаандаа ирсэн эсэх	Газрын бүх мэргэжилтнүүд	Бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
2.2	Худалдан авах ажиллагааны тайланд харьяа бүх байгууллагыг нэгтгэсэн эсэх	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
3. ХАА-г цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлсэн байдал /5 оноо/				
3.1	ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан бүх үйл ажиллагаа цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн эсэх	Газрын бүх мэргэжилтнүүд	Бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
4. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан байдал /5 оноо/				
4.1	Тендер шалгаруулалтын үр дүнг www.tender.gov.mn системд нийтэлсэн байдал	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
5. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдол шийдэгдсэн байдал /10 оноо/				
5.1	Гомдол захиалагчийн талд шийвэрлэгдсэн байдал	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	10 хүртэлх оноогоор дүгнэнэ.
6. Харьяа байгууллагын худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, гарсан зөрчлийг цаг алдалгүй засуулсан байдал /5 оноо/				
6.1	Харьяа байгууллагын худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, арга зүйн зөвлөмжөөр хангасан байдал	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.

7. Бусад /10 оноо/				
7.1	Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан эсэх	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
7.2	Ерөнхий гэрээний журмын дагуу худалдан авалт хийсэн байдал	Газрын бүх мэргэжилтнүүд	Хагас, бүтэн жилээр	5 хүртэлх оноогоор дүгнэнэ.